Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн
414 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Эдийн засаг, хөгжлийн яам | Макро эдийн засгийн бодлогын газрын Өрсөлдөх чадварын судалгааны хэлтэс |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| Бизнес эрхлэлтийн индекс хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-7 |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдөр 8 цаг | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын бизнес эрхлэлтийн индексийн индексийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалт, зөвлөмж, эрх зүйн дэмжлэгээр хангах, үзүүлэлтийг тооцож буй олон улсын байгууллагуудыг шаардлагатай, үнэн, зөв мэдээллээр хангах чиглэлээр арга хэмжээ авч, үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.

| Албан тушаалын зорилт:<br><br>1. Улсын бизнес эрхлэлтийн индексэд судалгаа, шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, индексийг сайжруулах, эрэмбийг ахиулахад шаардлагатай санал, зөвлөмж бэлтгэх;<br>2. Бизнес эрхлэлтийн индексийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудад эрх зүйн болон холбогдох дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах, үнэн, зөв мэдээлэл хүргэх;<br>3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх. | | | |
|---|---|---|---|
| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах - Т,<br>Хариуцан гүйцэтгэх - Г<br>Хянах – Х<br>Шийдвэрлэх – Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | Улсын бизнес эрхлэлтийн индексэд шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, тайлбар, танилцуулга, бэлтгэх; | Судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах | Г, Т |
| | Бизнесийн эрхлэлтийн индексийг олон улсын түвшинтэй харьцуулалт хийж сайжруулах бодлогын санал, зөвлөмж боловсруулах. | | Г, Т |
| 2 дугаар зорилтын хүрээнд | Бизнес эрхлэлтийн индексийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах, үнэн, зөв мэдээлэл хүргэх, түгээх чиглэлд уялдаж ажиллах; | Мэдээллийн урсгал болон хамтын ажиллагааг сайжруулсан байх | Г, Т |
| | Бизнес эрхлэлтийн индексийг сайжруулах чиглэлээр холбогдох төрийн байгууллагуудтай уялдан ажиллаж, нэгдсэн зохицуулалт, зөвлөмжөөр ханган ажиллах. | | Г, Т |
| 3 дугаар зорилтын хүрээнд | Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон газрын дотоод ажилд оролцох; | Хууль тогтоомжийн бодлогын хэрэгжилтийг хангаж ажилласан байх | Г, Т |
| | Удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, цаг үеийн нөхцөл байдлын талаар дүн шинжилгээ хийж, тайлбар танилцуулга бэлтгэж удирдлагыг тухай бүр мэдээллээр хангаж ажиллах. | | Г, Т |

МОНГОЛ УЛС ЗӨВШООРОВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

<table>
<tr><td></td><td colspan="2">Өөрийн хариуцан боловсруулсан албан бичиг, баримт бичгийг бичиг хэргийн стандартад нийцүүлэх, Засгийн газрын эдийн засгийн бодлого, түүний үр нөлөөний талаар судалгаа, тооцоо хийх.</td><td>Стандартыг хангаж ажилласан байна.</td><td>Г, Т</td></tr>
<tr><td colspan="5">III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</td></tr>
<tr><td>Боловсрол</td><td colspan="4">Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.</td></tr>
<tr><td>Мэргэжил</td><td colspan="4">- Нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан /0311, 031406/;<br>- бизнес ба удирдахуй /0411, 041201-041203,041301, 041303, 041401, 041601/;<br>- математик, статистик /054101-054102,054105, 054201/;<br>- эрх зүй /0421/.</td></tr>
<tr><td>Мэргэшил</td><td colspan="4">-</td></tr>
<tr><td>Туршлага</td><td colspan="4">Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.</td></tr>
<tr><td rowspan="4">Ур чадвар</td><td>Дүн шинжилгээ хийх</td><td colspan="3">- мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах;<br>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;<br>- байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх;<br>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх.</td></tr>
<tr><td>Асуудал шийдвэрлэх</td><td colspan="3">- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;<br>- өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;<br>- асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох;<br>- удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах.</td></tr>
<tr><td>Багаар ажиллах</td><td colspan="3">- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох</td></tr>
<tr><td>Бусад</td><td colspan="3">- кирилл болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх;<br>- гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар;<br>- ажил сайжруулах санааг эрэлхийлж, шинэ санаа гаргадаг байх.</td></tr>
<tr><td colspan="5">IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ</td></tr>
<tr><td colspan="5"><u>Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр</u>:<br><br>Макро эдийн засгийн бодлогын газрын дарга;<br>Өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга.</td></tr>
</table>

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект<br>- Төрийн болон орон нутгийн байгууллагын холбогдох албан тушаалтан;<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;<br>- Гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн холбогдох албан тушаалтан, гадаадын иргэн хуулийн этгээд;<br>- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага, бусад хуулийн этгээд. |
|---|---|
| **V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ** | |
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br><br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА<br><br>.............................. (Б. Дашпүрэв)<br><br>2023 оны 10 дугаар сарын 31-ны өдөр | Байгууллагын нэр:<br><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><br>Шийдвэрийн огноо: 23 1006<br><br>414<br>Дугаар: ................................ |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| Байгууллагын нэр:<br><br>ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ<br><br>Шийдвэрийн огноо: 2023.10.31<br><br>Дугаар: А/210<br><br>(тамга/ тэмдэг)<br><br>ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА .............................. (И.БАТХҮҮ)<br><br>2023 оны 10 дугаар сарын 31 -ны өдөр | |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ